

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/117/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: [ariunaa.ch@audit.gov.mn](mailto:ariunaa.ch@audit.gov.mn)

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70503020 Цахим хаяг: [lundegmaa.ts@audit.gov.mn](mailto:lundegmaa.ts@audit.gov.mn)

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020 Цахим хаяг: [uranbileg.b@audit.gov.mn](mailto:uranbileg.b@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

**АГУУЛГА**

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

## 1 Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ШҮҮХИЙН  
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА  
Л.БОЛДСАЙХАН ТАНАА**

2019.02.25 № 1-6/119Б  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар дагуу Шүүхийн шинжилгээний алба нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон

9828881

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Шүүхийн шинжилгээний алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Л.Болдсайхан-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019/02/17-наас 2019/02/18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019/02/20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019/02/01-ны өдрийн 13ж/33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь “Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д зааснаар Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэж заасны дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт зардлын дүн хөрөнгийн дүнгээс бага байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны *Нийт зардал* 2,136.27 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 2,136.27 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь 1 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 6 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	965.1	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

2018 оны 8 дугаар сард ажилчдын цалинг бодохдоо Ц.Цэндсүрэнгийн цалингаас ХХОАТ-ыг суутгалгүйгээс нийт 65.3 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон байна.

Энэ нь “Үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйл тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Дээрх илүү олгосон цалингийн дүнгээр төлбөрийн акт тогтоох.

2018 онд тус байгууллагын ажиллагсдын ээлжийн амралтын олговрыг дундаж цалин хөлснөөс хоолны хөнгөлөлтийг хасаж тооцоогүйгээс 899.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралтын олговор тооцох журам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тооцох журам" тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Илүү тооцож олгосон дээрх дүнгээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Тус байгууллага нь 2018 оны жилийн эцсээр бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч илтгэх хуудсаар хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж, батлагдсан маягтаар тайлагнаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ыг баримталж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн:** Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийхдээ Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ыг баримталж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Бараа үйлчилгээний 225.0 мянган төгрөгийн гүйлгээг холбогдох дансдаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж, тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх бүртгэлийн алдааг хүлээн зөвшөөрч бүртгэлийг залруулав.

Тус байгууллага нь 2018 оны жилийн эцсийн байдлаар татварын 1139.2 мянган төгрөгийн өглөгтэй байсан боловч үүнийг санхүүгийн тайланд тусгаж, тайлагнаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх бүртгэлийн алдааг хүлээн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж залруулав.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

### **2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд нийт 195331.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 192810.9 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь орон дутуу байгаагаас шалтгаалжээ.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 0 хувьтай байна. Энэ нь тухайн байгууллагын нягтлан бодогч солигдож, аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээлгэн өгөөгүй байна.

### **2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 ЗАРДЛЫН ДАНС**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тус байгууллага нь 2018 оны жилийн эцсээр бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч илтгэх хуудсаар хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж, батлагдсан маягтаар тайлагнаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ыг баримталж ажиллаагүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг буруу тайлагнах.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийхдээ Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ыг баримталж ажиллаагүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019/07/05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,352,750.00</b>	<b>4,833,714.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	7,207.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	7,207.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	7,207.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	7,207.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	965,147.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	965,147.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8,352,750.00	3,861,360.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	872,500.00	730,500.00
35130	Эм боох материал	872,500.00	730,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,480,250.00	3,130,860.00
35410	Бичиг хэргийн материал	350,500.00	399,000.00
35420	Аж ахуйн материал	5,747,790.00	1,506,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	480,000.00	480,000.00
35440	Түлш, шатах тослох материал	876,100.00	720,000.00
35470	Бусад хангамжийн материал	25,860.00	25,860.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,424,037.52</b>	<b>119,807,697.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	44,424,037.52	119,807,697.84
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	44,424,037.52	76,671,697.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,702,334.00	56,561,820.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,137,993.22	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	19,800,000.00	19,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,950,000.00	-19,250,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,469,154.24	53,413,891.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,012,120.44	-35,482,199.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,531,832.89	6,531,832.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,979,169.95	-4,903,647.05
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	43,136,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	43,136,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>52,776,787.52</b>	<b>124,641,411.84</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>1,139,216.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	1,139,216.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	1,139,216.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>52,776,787.52</b>	<b>123,502,195.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	52,776,787.52	123,502,195.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,502,053.00	80,638,053.00
51101	Өмч: - төрийн	37,502,053.00	80,638,053.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	15,271,373.50	37,020,180.36
51210	Өмнөх үеийн үр дүн	15,271,373.50	15,271,373.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	21,748,806.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,361.02	5,843,962.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>52,776,787.52</b>	<b>124,641,411.84</b>

Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>135,324,354.04</b>	<b>235,339,593.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,027,654.04</b>	<b>42,018,650.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,027,654.04	42,018,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,027,654.04	42,018,650.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,528,700.00	10,577,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,498,954.04	31,441,050.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>124,296,700.00</b>	<b>193,320,943.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	123,646,700.00	186,834,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	123,646,700.00	186,834,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	650,000.00	6,486,843.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	650,000.00	6,486,843.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>125,413,670.57</b>	<b>213,590,786.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>125,413,670.57</b>	<b>213,590,786.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	125,413,670.57	208,990,060.69
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106,886,496.00	149,068,284.00
210101	Үндсэн цалин	106,886,496.00	106,610,073.00
210102	Нэмэгдэл	00.00	31,159,118.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,299,093.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,959,672.00	4,105,548.55
210201	Тэтгэврийн даатгал	1,210,384.00	1,607,867.00
210202	Тэтгэмжийн даатгал	145,512.00	106,412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	181,891.00	70,176.00
210204	Ажилгүйдлийн даатгал	36,380.00	30,353.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,385,505.00	2,290,740.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,960,976.00	11,778,771.00
210301	Гэрэл, цахилгаан	114,580.00	428,691.00
210302	Түлш, халаалт	2,446,196.00	3,320,000.00
210304	Байрны түрээс	00.00	8,030,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,709,110.00	12,143,053.00
210401	Бичиг хэрэг	855,700.00	1,284,478.00
210402	Тээвэр, шатахуун	3,477,010.00	8,155,610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	786,700.00	1,599,965.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	581,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	589,700.00	521,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,400,700.00	4,531,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	725,700.00	2,759,000.00
210502	Хоол, хүнс	675,000.00	1,772,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	600,300.00	13,786,363.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,300.00	532,000.00
210604	Урсгал засвар	00.00	13,254,363.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,744,000.00	4,323,450.00
210702	Дотоод албан томилолт	1,744,000.00	4,323,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	510,000.00	1,459,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	510,000.00	1,199,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	20,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,642,416.57	7,793,991.14
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,642,416.57	7,793,991.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	4,600,725.45
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	4,600,725.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,600,725.45
213304	Хөрөнгийн	00.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>9,910,683.47</b>	<b>21,748,806.86</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,910,683.47</b>	<b>21,748,806.86</b>

Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>178,240,700.00</b>	<b>203,898,543.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,626,000.00</b>	<b>10,577,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,626,000.00	10,577,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,626,000.00	10,577,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,626,000.00	10,577,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>173,614,700.00</b>	<b>193,320,943.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	169,466,000.00	186,834,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,148,700.00	6,486,843.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	650,000.00	6,486,843.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,498,700.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>176,038,700.00</b>	<b>203,898,543.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>176,038,700.00</b>	<b>203,898,543.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>170,149,241.00</b>	<b>199,297,817.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	144,509,388.00	148,937,543.85
210101	Үндсэн цалин	137,465,630.00	84,899,544.00
210102	Нэмэгдэл	00.00	47,249,999.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,043,758.00	16,788,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,163,183.00	3,844,426.70
210201	Тэтгэврийн даатгал	1,646,764.00	2,045,499.00
210202	Тэтгэмжийн даатгал	220,384.00	106,412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,231.00	70,176.00
210204	Ажилгүйдлийн даатгал	55,837.00	30,353.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,965,967.00	1,591,986.70
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,766,500.00	11,778,771.00
210301	Гэрэл, цахилгаан	700,000.00	428,691.00
210302	Түлш, халаалт	3,600,000.00	3,320,000.00
210304	Байрны түрээс	00.00	8,030,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,340,000.00	12,627,853.00
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,399,978.00
210402	Тээвэр, шатахуун	4,900,000.00	7,999,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,599,965.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	703,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	740,000.00	925,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,900,000.00	4,034,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	2,499,500.00
210502	Хоол, хүнс	900,000.00	1,535,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,300,170.00	8,799,673.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	799,600.00
210604	Урсгал засвар	2,096,670.00	8,000,073.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	2,400,000.00	4,785,450.00
210702	Дотоод албан томиллолт	2,400,000.00	4,785,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	770,000.00	4,489,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	770,000.00	4,229,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	20,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,889,459.00</b>	<b>4,600,725.45</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,799,459.00	4,600,725.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30.00	4,600,725.45
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,202,000.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,202,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,202,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,202,000.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-2,202,000.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	37,502,053.00	3,361.02	13,961,599.19	51,467,013.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>37,502,053.00</b>	<b>3,361.02</b>	<b>13,961,599.19</b>	51,467,013.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,910,683.47	9,910,683.47
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,502,053.00</b>	<b>3,361.02</b>	<b>15,271,373.50</b>	52,776,787.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>37,502,053.00</b>	<b>3,361.02</b>	<b>15,271,373.50</b>	52,776,787.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	5,840,601.46	-	5,840,601.46
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	43,136,000.00	-	21,748,806.86	64,884,806.86
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>80,638,053.00</b>	<b>5,843,962.48</b>	<b>37,020,180.36</b>	123,502,195.84

Шүүхийн шинжилгээний албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/**

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,334,100.00	192,810,974.55	2,523,125.45	98.71
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	195,334,100.00	192,810,974.55	2,523,125.45	98.71
210	Бараа, үйлчилгээний зардал	195,334,100.00	192,810,974.55	2,523,125.45	98.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,452,300.00	148,937,543.85	514,756.15	99.66
210101	Үндсэн цалин	85,414,300.00	84,899,544.00	514,756.00	99.40
210102	Нэмэгдэл	47,250,000.00	47,249,999.85	0.15	100.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	16,788,000.00	16,788,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,885,700.00	3,844,426.70	1,041,273.30	78.69
210201	Тэтгэврийн даатгал	2,110,300.00	2,045,499.00	64,801.00	96.93
210202	Тэтгэмжийн даатгал	200,000.00	106,412.00	93,588.00	53.21
210203	ҮОМШӨ ний даатгал	250,000.00	70,176.00	179,824.00	28.07
210204	Ажилгүйдлийн даатгал	50,000.00	30,353.00	19,647.00	60.71
210205	Эрүүл мэндийн даатгал	2,275,400.00	1,591,986.70	683,413.30	69.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,354,000.00	11,778,771.00	575,229.00	95.34
210301	Гэрэл цахилгаан	500,000.00	428,691.00	71,309.00	85.74
210302	Түлш, халаалт	3,320,000.00	3,320,000.00	-	100.00
210304	Байрны түрээс	8,534,000.00	8,030,080.00	503,920.00	94.10
2104	Хангамж, бараа материалын зардал	12,800,000.00	12,627,853.00	172,147.00	98.66
210401	Бичиг хэрэг	1,400,000.00	1,399,978.00	22.00	100.00
210402	Тээвэр (шатахуун)	8,000,000.00	7,999,510.00	490.00	99.99
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,599,965.00	35.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	703,100.00	96,900.00	87.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,000,000.00	925,300.00	74,700.00	92.53
2105	Нормативт зардал	4,036,000.00	4,034,500.00	1,500.00	99.96
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,500,000.00	2,499,500.00	500.00	99.98
210502	Хоол, хүнс	1,536,000.00	1,535,000.00	1,000.00	99.93
2106	Эд хогшил худалдан авах	5,346,000.00	5,342,830.00	3,170.00	99.94
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	800,000.00	799,600.00	400.00	99.95
210604	Урсгал засвар	4,546,000.00	4,543,230.00	2,770.00	99.94
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	4,785,450.00	214,550.00	95.71
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	4,785,450.00	214,550.00	95.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,460,100.00	1,459,600.00	500.00	99.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	1,199,600.00	400.00	99.97
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,100.00	90,000.00	100.00	99.89
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195,334,100.00	197,411,700.00	(2,077,600.00)	101.06
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,634,500.00	186,834,100.00	(1,199,600.00)	100.65
131001	Улсын төсвөөс санхүүжих	185,634,500.00	186,834,100.00	(1,199,600.00)	100.65
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,699,600.00	10,577,600.00	(878,000.00)	109.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,699,600.00	10,577,600.00	(878,000.00)	109.05
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
620001	Удирдах ажилтан	-	-	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-

#### 4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,486,843.00	(6,486,843.00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	6,486,843.00	(6,486,843.00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	6,486,843.00	(6,486,843.00)	-
2106	Эд хогшил худалдан авах	-	3,456,843.00	(3,456,843.00)	-
210604	Урсгал засвар	-	3,456,843.00	(3,456,843.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	3,030,000.00	(3,030,000.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,030,000.00	(3,030,000.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,486,843.00	(6,486,843.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,486,843.00	(6,486,843.00)	-
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,486,843.00	(6,486,843.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				
620003	Үйлчлэх ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-